



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ”  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 5/38

Бор-Өндөр сум

Ажилчдад улирлын ажлын үр дүнгийн  
мөнгөн урамшуулал олгох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.3, 4.8, 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн гүйцэтгэлийн чанар, үр дүнг харгалзан ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй байдлыг харгалзан 2025 оны 02 дугаар улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хавсралтад дурдсан нэрс, хувь хэмжээний дагуу олгосугай.

2. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 2025 оны 06 дугаар сард бодож олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙН  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.АМАРЖАРГАЛ

